

ЭГЭЭББ судалгааны төсөл, Монгол улс

Цэнхэр сум, Хураангуй тайлан

2019 оны 2-р сар

Е. Далей, Я. Нарангэрэл, З. Дрисколл, К. Ланз, Н. Лхамдулам, Б.
Мөнхтүвшин, Б. Сувд & Ж. Грахам



Монгол улсад хэрэгжиж буй ЭГЭЭББ судалгааны төслийн хүрээнд 2019 оны 2-р сард эрхлэн гаргасан Цэнхэр сумын тайлангийн (www.mokoro.co.uk/wolts) гол үр дүнг энэхүү хураангуй тайланд харуулав.

Текст © ЭГЭЭББ төслийн баг. Бүх фото зураг © ЭГЭЭББ төслийн баг.

Танилцуулга, аргачлал

Мокоро байгууллагын практик, үйл ажиллагаанд суурилсан урт хугацааны стратеги баримтлан гүйцэтгэж буй Эмэгтэйчүүдийн газар эдэлбэрийн эрхийн баталгаат байдал (ЭГЭЭББ) судалгааньтөсөл нь “Монгол болон Танзани улс дахь эмэгтэйчүүдийн газар эдэлбэрийн баталгаат байдалд учрах аюулыг судлах” гэсэн судалгааны арга зүйг түршиж байгаа юм. Монгол улс дахь Хүн Төвтэй Байгаль Хамгаалал ТББ- тай хамтран уул уурхайн хөрөнгө оруулалтын нөлөөлөлд өртсөн бэлчээрийн газар нутаг дахь эмэгтэйчүүдийн газар эдэлбэрийн баталгаат байдал ямар байгааг танадан судалж, эмэгтэйчүүдийн болон нийгмийн эмзэг бүлгийн газрын эрхэд учруулахгол аюулуудыг тогтоохын тулд хамтын оролцооны болон тоон судалгааны аргын аль альныг нь ашиглан судалгаа хийж байна. ЭГЭЭББ төслийн зорилго нь газар эдэлбэрийн засаглал дахь жендэрийн эрх тэгш байдлыг сайжруулах болон орон нутаг дахь эмзэг бүлгийнхний газрын эрхийг баталгаажуулах боломжийг судалж, улмаар газар болон байгалийн нөөцөд учрах аюул заналаас хамтаараа сэргийлэхэд нутгийн иргэдэд туслах зорилготой билээ. (ЭГЭЭББ төслийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг манай цахим хуудаснаас үзээрэй: <http://mokoro.co.uk/project/wolts>)

Энэхүү хураангуй тайланд 2017 оны 10-р сараас 2018 оны 8-р сарын хооронд бидний хийсэн анхны танилцах аялал, суурь судалгаа болон хамтын оролцоотой судалгаанаас гарсан үр дүнг танилцуулж байна. Мөн бид 2018 оны 12-р сард орон нутагт эргэн очиж судалгааны анхан шатны үр дүнг танилцуулж, баталгаажуулсан юм. Бид Цэнхэр сумын ард иргэдийн найрсаг зочломтгой зан, сумын засаг захиргааны дэмжлэгт талархаж байна. Бид 2018 оны 2, 3- р сард Цэнхэр сумын бүх багийн өрхийн 10% -ыг хамруулсан суурь судалгаа хийсэн. Нийт 170 өрх хамрагдсан бөгөөд 137 өрх нь санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон, нэмж 24 өрх толгойлсон эмэгтэйтэй өрх, 9 өрх толгойлсон эрэгтэйтэй өрх байв. Өөрөөр хэлбэл нийт судалгаанд хамрагдсан өрхийн 81% нь санамсаргүй түүврийн аргаар сонгосон (117 эрэгтэй болон 20 өрх толгойлсон эмэгтэйтэй өрх), 19% нь зориудаар сонгосон өрх толгойлсон эмзэг бүлгийн эмэгтэйтэй эсхүл эрэгтэйтэй өрх байв. Ингэж эмзэг бүлгийн өрхийг судалгаанд олноор хамруулж эмзэг бүлгийн жендэрийн асуудлыг олж тогтоох зорилготой байв. Ийнхүү судалгаанд нэмэлтээр хамрагдсан 33 өрхөөс авсан мэдээллийг суурь судалгааны ерөнхий дүн шинжилгээнд оруулалгүй зөвхөн өрх толгойлсон эмэгтэйтэй эсхүл эрэгтэйтэй өрхийг харьцуулсан дүн шинжилгээ хийхэд хэрэглэв.

Бид 2018 оны 8-р сард хамтын оролцооны аргаар судалгаа хийж нийт 12 зорилтот бүлгийн уулзалт (ЗБУ), 19 хувь хүмүүстэй ярилцлага (ХХЯ) хийж 124 хүнтэй уулзсан байна. Суурь судалгааны шинжилгээний үр дүнд үндэслэн янз бүрийн асуудал, онцлогийг шинжлэхийн тулд цаашид нарийвчлан судлах шаардлагатай гэж үзсэн янз бүрийн нийгмийн бүлгийн төлөөллүүд болон хувь хүмүүстэй тусгайлсан уулзалт, ярилцлага хийхийг зорьсон (жишээ нь, бэлэвсэн хүмүүс, уурхайчид, гэрлэсэн эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүд гэх мэт). ЗБУ-ын бүтцийг оролцооны аргуудыг ашиглаж боловсруулсан (байгалийн нөөцийн зураглал, нүүдлийн зураглал, улирлын хөдөлмөрийн ачаалал, оролцогч талуудын зураглал, дүн шинжилгээ). ХХЯ – ын бүтцийг урьдчилан боловсруулж, ярилцлага хийж буй хувь хүний нөхцөл байдалд тохируулан тэдний амь амьдрал, амьжиргааны талаар, хүүхэд байхаас нь эхлээд янз бүрийн байгалийн нөөцийг олж хүртэх хэлбэр, жендэрийн харилцааны талаар аль альных нь тухай мэдэж авах зорилготой асуултууд байв. Мөн бид судалгааныхаа хүрээнд орон нутгийн засаг захиргааны мэргэжилтнүүд, Цэнхэр суманд ажиллаж буй уул уурхай, аялал жуулчлалын компаниудын төлөөллүүдтэй ярилцлага хийсэн. Мөн орон нутгийн иргэдэд судалгааны анхны тайланг танилцуулж, санал авч, баталгаажуулах уулзалтыг (САБУ) хамтын оролцооны аргаар 5 удаа хийж, орон нутгийн захиргаатай САБУ -г 2018 оны 8 –р сард хийсэн.

Байршил, хүн ам

Цэнхэр сумын нутаг Улаанбаатар хотоос баруун хойд зүгт 452 км-ийн зайд Архангай аймагт оршдог. Нийт газрын хэмжээ 332, 803.1 га бөгөөд үүнээс 149,042.9 га хөдөө аж ахуйн газар (бэлчээр ба хадлангийн талбай, 320.4 га хуучин газар тариалангийн талбай), 73,720 га ой, 89,226 га Хангай нурууны Байгалийн цогцолборт газарт хамаардаг ба 9,636.81 га нь сумын төвийн суурьшлийн бүс юм. 2017 оны байдлаар уул уурхайн ашиглалтын 5 лиценз олгогдсон байсан. Цэнхэр сумын ашигт малтмалын үндсэн нөөц алт юм.

Цэнхэр сум 6 багтай; сумын төвийн Тамир баг илүү суурьшмал, харин бусад бүх багт нүүдлийн мал аж ахуйн газар ашиглалтын хэлбэр зонхилно. 2017 оны 12 сарын байдлаар 1,685 өрхийн 5,892 хүн амтай байв. Сумын хүн амын дундаж нягтрал нэг га-д 0.18 хүн байв.

Манай суурь судалгааны санамсаргүй түүвэрт өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн тоо 14.6% эзэлж байв. Үүнийг сумын хэмжээнд шилжүүлэн тооцвол судалгааны үед Цэнхэр сумын хэмжээнд нийт 245 өрх толгойлсон эмэгтэйтэй өрх байсан гэсэн тооцоо гарч байна. Мөн манай судалгаагаар Цэнхэр сумын хүн амын 38% нь 18 болон түүнээс доош настай, 3% нь ахмад настай (65 буюу түүнээс дээш), 59% нь хөдөлмөрийн насны насанд хүрсэн хүмүүс (19-64 настай) байна гэсэн тооцоо гарч байна. Насанд хүрсэн залуу хүний (19-24, 25-34) тооноос хамааран Цэнхэр сумын хүн ам залуужсан онцлогтой байв. Бидний санамсаргүй түүврийн өрхийн хөдөлмөрийн насны хүн амын 44%-ийг залуучууд эзэлж байв. Түүнчлэн санамсаргүй түүврийн нийт 137 өрхийн хүмүүсийн 64% нь 35 болон түүнээс доош настай байв. Цэнхэр сумын хүн амын дийлэнх нь халх, буддын шашин шүтлэгтэй хүмүүс байв.

Хүн ам, эдийн засгийн өөрчлөлтийн сүүлийн үеийн түүх

Социализмын үед Цэнхэр сум Монгол улсын жирийн нэгэн сум байв. Мал аж ахуй голлосон социалист хөгжлийн бодлоготой байсан ба газар тариаланг маш бага хэмжээгээр хөгжүүлж байв. 1950 оноос хойш нэгдэл үүссэнтэй холбоотойгоор Цэнхэр сумын өрхийн ихэнх нь нэгдлийн мал маллаж, сүү сааж, улмаар улсад хөдөлмөрлөх болсон. Ингэж урьд нь нутгийн ахмад буурлууд нь зохицуулж, удирддаг байсан уламжлалт хэв маяг өөрчлөгдөж албан ёсоор нэгдлийн удирдлагад орох болсон. Нэгдлийн үед хүн, малын улирлын тогтмол нүүдэл, сүүдлыг улсаас анхаарч, тээвэрлэлтэд малчин өрхөд дэмжлэг үзүүлдэг байсан. Мөн мал эмнэлэг болон бусад үйлчилгээг улсаас үзүүлдэг байв. Өрх айл хувьдаа 30-40 тооноос илүү малтай байхыг хориглодог бөгөөд энэ тооноос илүү гарсан малыг нэгдлийн өмчид хураан авдаг байв.

1990 оны ардчилсан хувьсгалын дараагаар нэгдэл задарч Монгол орон даяар, Цэнхэр сумын малчид ч ялгаагүй малаа хувьчлан авсан. Энэ нь малчдыг дахин илүү олон тооны малтай болох замыг тавьж, 1990 оноос хойш олдсон энэхүү эрх чөлөө нь одоогийн сумын бэлчээрийн доройтолд (харьцангуй) их бага хэмжээгээр нөлөөлсөн гэж харагдаж болох талтай. Цэнхэр суманд сургууль завсардсан хүний тоо бас нэмэгдсэн. Монгол улсын эдийн засгийн хямралаас шалтгаалан хүмүүс амьжиргаагаа залгуулах үүднээс эргэн мал маллах эсхүл шинээр малчин болох үедээ хувьчилж авсан малаа маллах, хүнд хүчир ажилд туслуулахын тулд ялангуяа эрэгтэй хүүхдүүдийг сургууль завсардуулж байсан. Ингэснээр тэдний боловсролын түвшин харьцангуй доошилж, бидний судалгааны үеэр 30 нас хол гарсан нутгийн залуу эрэгтэй малчдын дунд нийгмийн сөрөг үр дагаварууд бий болсон нь харагдсан.

1990 - ээд оны дундаас сүүл үед уул уурхай илүү эрчимтэй явагдах болсон ч түүнээс өмнө нутгийн зарим малчид нэмэлт мөнгөн орлого олох зорилгоор хууль бус, гар аргаар (нинжа маягаар) алт олборлож эхэлсэн байдаг.

Цэнхэр сумын иргэдийн ихэнх нь энэ нутагтаа төрсөн ба ардчилсан хувьсгалын дараагаар сумын нийт хүн ам харьцангуй бага өөрчлөгдсөн; одоогийн шилжилт хөдөлгөөний цэвэр хувь тэгтэй тэнцэж байна. Яагаад гэвэл социализмын үед Цэнхэр суманд газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй маш бага хэмжээгээр хөгжсөн учир шилжин ирэгсдийн хөдөлгөөн бага байсан.

Монгол орны бусад газарт социалист дэглэмийн тушаалаар хүмүүс өөр газар очиж, шилжин суурьшдаг байсантай адилгүй байв.

Амьжиргаа ба жендэрийн харилцаа

Гэрлэлт, гэр бүлийн нөхцөл байдал

Бидний суурь судалгаанаас харахад Цэнхэрийн ихэнх насанд хүрсэн иргэд хууль ёсоор гэрлэсэн байсан ч их хэмжээний өрх толгойлсон эмэгтэйчүүд олонтой харагдсан. Манай суурь судалгааны өрх толгойлсон эмэгтэйтэй нийт өрхийн 82% нь өрх толгойлсон бэлэвсэн эмэгтэйчүүд байв. Харин өрх толгойлсон эрэгтэйтэй нийт өрхийн зөвхөн 10% нь өрх толгойлсон бэлэвсэн эрэгтэйтэй байв. Бэлэвсэн хүний тоо өндөр байгааг архидалттай холбож бодож үзсэн. Салалтын хэмжээ бага, санамсаргүй түүврийн өрхийн зөвхөн 5% нь гэр бүл салсан өрхийн тэргүүнтэй байсан ч уламжлалт нийгмийн систем давамгайлсан Монгол орны энэ нутагт энэ тоог харьцангуй их гэж үзэж болох юм. Санамсаргүй түүврийн өрхийн 12% нь дор хаяж нэг хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй байсан.

Санамсаргүй түүврийн өрхийн гишүүдийн зөвхөн 72% нь өрхийн үндсэн сууцанд буюу гэртээ ихэнхдээ амьдардаг гэсэн байна. Гэрээсээ хол амьдарч байгаа шалтгаан нь сургуулийн насны хүүхдүүд, Улаанбаатар юмуу гадаадад сурдаг оюутнууд, аймгийн төвд эсхүл Монгол орны хаа нэгтээ мэргэжлийн юмуу үйлчилгээний газарт ажилладаг, мөн өөр газар очиж ажил хайж байгаа гэсэн цөөн хэдэн хүн байв. Түүнчлэн санамсаргүй түүврийн өрхийн гишүүдийн 23% нь заримдаа улирлын шинж чанартай өөр газар амьдардаг гэсэн байв. Ийм өрхийн ихэнх нь хичээлийн жилд аймаг юмуу сумын төвд хүүхдээ сургуульд сургаж, асран хамгаалдаг хүмүүс байв. 8 өөр өрхийн 8 гишүүн зуны цагт малаа хариулан нүүдэг гэж мэдээлсэн байна. Учир нь малчин өрх ихэвчлэн ганц нэгээрээ бүс өрхөөрөө улирлын нүүдэл хийдэгтэй холбоотой юм. Манай суурь судалгааны мэдээллээс үзвэл суман дахь улирлын нүүдэл нь бүхэлдээ боловсрол, бэлчээрийн мал аж ахуйтай холбоотой бөгөөд сумын алтны уурхайд бэлэн мөнгө олохын тулд улирлын шинж чанартай ажил хийх зэрэг шалтгаан байхгүйг харуулж байна.

Боловсрол

Жендэрээс шалтгаалан боловсролын түвшин эрс ялгаатай байгаа нь тодорхой байсан ба дундаас дээш боловсролтой (тусгай мэргэжлийн сургууль юмуу их сургууль) эмэгтэй гишүүнтэй өрхийн (36%) тоо эрэгтэй гишүүнтэй өрхийн тооноос (15%) хамаагүй их байв. Манай ЗБУ, ХХЯ-аас харахад гэр бүлүүд охидоо дунд сургууль, их сургуульд сургаж, хөвгүүдээ малчин болгодог байсан байна. Олон охид, эмэгтэйчүүд нутагтаа эргэж очоогүй учир эрэгтэй залуу малчдад эхнэртэй болох явдал хүндрэлтэй болсон байна. Мөн ерөнхийдөө хүүхдүүдээ сургуульд сургаж, өндөр боловсрол эзэмшүүлэхээр явуулсан малчид хүссэн үр дүндээ хүрээгүй, хүүхдүүдийнх нь ихэнх ажилгүй эсхүл жижиг бизнес, үйлчилгээний газар ажилладаг болсон байна.

Хөрөнгө чинээ, ядуурал

Санамсаргүй түүврийн өрхийн 91% нь уламжлалт гэртэй, 6% нь байшинтай, 3% нь аль алинтай нь байв. Ялгаагүй эрэгтэй, эмэгтэй тэргүүнтэй өрхийн орон сууцны үндсэн материал эсгий байв. Хамтын оролцооны судалгааны үеэр айл өрхүүдийн гэрээ засч, янзалдаг ерөнхий стандарт өндөр байгааг бид ажигласан юм. Үүнийг магадгүй тэд ойн нөөцтэй ойр байдаг учир гэрийн модон хэсэг, эдлэлээ өөрсдөө засахад хялбар байдаг, түүнчлэн суман дээр хэд хэдэн хөрөө рам ажиллаж, гэрийн модон хэсгийг хангадагтай холбож үзэж болох юм. Санамсаргүй түүврийн өрхийн ихэнх цахилгаантай буюу нарны эрчим хүчтэй холбогдсон байсан. Мөн ихэнх нь зурагт, гар утастай байсан. Гэхдээ тавиас бага хувь нь хөргөгч, угаалгын машин, мөнгөн аягатай байсан ба зөвхөн 5% нь радиотой байв. Сумын хэмжээгээр эрэгтэй тэргүүнтэй өрхүүд эмэгтэй тэргүүнтэй өрхүүдээс хувь илүүтэйгээр зурагт, гар утас, хөргөгч, угаалгын машин, мөнгөн

аягатай байв. Жендэрээс шалтгаалан мөнгөн аягатай байх нь хамгийн их ялгаа байв. Энэ нь мөнгөн аяга малчин хүний хөрөнгөө хадгалах уламжлалт арга ухаан байдаг учир өрх толгойлсон эмэгтэйтэй малчин өрхийн хувьд эрэгтэй тэргүүнтэй малчин өрхтэй харьцуулахад амьжиргаа муу байгааг харуулж байж болох юм.

Суурь судалгаанд хамрагдсан өрхүүдээс төвийн усан хангамжид холбогдсон өрх байгаагүй бөгөөд ихэнхдээ голоос, цаашлаад төлбөртэй гүний худгаас усаа авдаг байна. Үүнд жендэрийн хэд хэдэн ялгаа харагдсан. Дотор байрладаг жорлон бараг үгүй, ихэнхдээ татуургагүй гадна жорлонтой байв. Жорлонгүй өрх толгойлсон эмэгтэйтэй өрхүүдийн тоо эрэгтэй тэргүүнтэй өрхүүдээс арай илүү байсан; эрэгтэй тэргүүнтэй өрх нийтийн жорлон ашигладаг байна. Тээврийн хэрэгслийн бүх төрлийн хувьд - трактор, ачааны машин, дөрвөн дугуйн хөтлөгчтэй машин, хоёр дугуйн хөтлөгчтэй машин, мотоцикл, унадаг дугуй, гар тэрэг, морь, автобус зэргээс эрэгтэй тэргүүнтэй өрхүүдэд өрх толгойлсон эмэгтэйтэй өрхүүдтэй харьцуулахад илүү олон байгаа гэж мэдээлсэн.

Нийтдээ, манай суурь судалгааны мэдээллээс харахад Цэнхэр суманд орон сууцны материал, цахилгааны хангамж, орон сууц, эд хөрөнгийн өмчлөл, ус болон ариун цэврийн байгууллын хангамжийн хувьд эрэгтэй тэргүүнтэй өрх болон өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн хооронд ялгаагүй адил нөхцөл байдалтай гэж үзэж болно. Гэхдээ эзэмшиж буй тээврийн хэрэгслийн хувьд эрэгтэй тэргүүнтэй өрх, өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн хооронд ихээхэн ялгаа байгаа нь өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн амьжиргаа муу байгаа хийгээд өрх толгойлсон малчин эмэгтэйтэй өрхөд бэрхшээл их тулгардгийг харуулж байна. Энэ байдлыг манай ЗБУ, ХХЯ-аас баталж илрүүлсэн байгаа бөгөөд өрх толгойлсон эмэгтэйтэй өрх, ялангуяа насанд хүрсэн өөр гишүүнгүй тохиолдолд мал маллахад хүндрэлтэй байдгийг олж мэдсэн билээ.

Үндсэн амьжиргаа

Цэнхэр сумын хүмүүсийн үндсэн амьжиргаа нь улирлын тогтмол нүүдэлд түшиглэсэн уламжлалт мал аж ахуй юм. Гэхдээ мал аж ахуй энэ сумын хүмүүсийн амьжиргааны ганцхан эх үүсвэр биш бөгөөд санамсаргүй түүврийн нийт өрхийн 14% нь албан ажил эрхэлдэг өрхийн гишүүнтэй хэмээн мэдээлсэн. Ийм хүмүүсийн талаас илүүгүй хувь нь сумын төвийн Тамир багт амьдардаг байна. Тамир багийн санамсаргүй түүврийн өрхийн 43% нь албан ажил эрхэлдэг өрхийн гишүүнтэй байв. Санамсаргүй түүврийн өрхийн зөвхөн нэг нь “жигжиг хэмжээний албан ёсны уул уурхайн компанид ажилладаг” өрхийн гишүүнтэй, хоёр нь “бичил уурхайн компани эзэмшдэг” өрхийн гишүүнтэй гэж мэдээлсэн байна. Мөн манай ЗБУ, ХХЯ-ын оролцогчид байгалийн баялаг арвинтай сүм түл эмзэг болон боломжийн амьжиргаатай өрхийн аль аль нь ялгаагүй самар, жимс түүх гэх мэт улирлын чанартай ойн дагалт бүтээгдэхүүн ашиглаж амьжиргаандаа нэмэр болдог гэж мэдээлсэн юм.

Мал аж ахуй хамгийн чухал амьжиргааны эх үүсвэр хэдий ч санамсаргүй түүврийн өрхийн 52% нь сүүлийн 12 сарын турш мал аж ахуйгаас хамгийн их орлого олсон гэсэн ба 72% нь хоёр болон түүнээс дээш орлогын эх үүсвэртэй байсан байна. Бусад хамгийн өндөр орлогын эх үүсвэрүүдэд төрийн ажил эрхлэлт (8%), янз бүрийн нийгмийн халамжийн төлбөр (26%) – малгүй эсхүл цөөн малтай өрхийн орлого бүхэлдээ зөвхөн нийгмийн халамжийн мөнгө, уул уурхай (3%) байв. Цөөн хэдэн тохиолдолд өрхийн хамгийн их орлогын эх үүсвэр нь хувийн бизнес, дэлгүүр ажиллуулах, модны үйлдвэр, барилгын ажил байсан. Эрэгтэй тэргүүнтэй өрх, өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн хооронд том ялгаа байхгүй ч бэлэн мөнгөний орлогогүй нэг өрх нь өрх толгойлсон эмэгтэйнх байв.

Жендэрийн харилцаа

Цэнхэр сумын малчин өрхийн доторх хөдөлмөрийн хуваарь эрт дээр үеэс уламжлагдсан жендэрийн хэм хэмжээний дагуу зохицуулагддаг бөгөөд эрэгтэй хүмүүс мал маллах, галын түлээ бэлтгэх, малаа оторлуулах ба/юуу улирлын нүүдэл хийх зэрэг гэрийн гадаах ажлыг хийж, эмэгтэй хүмүүс сүү саах, цагаан идээ бэлтгэх, хүүхдээ асрах, хоолоо хийх зэрэг гэрийн

доторх ажлыг хийдэг байна. Гэвч, ЗБУ-ын үеэр эрэгтэй, эмэгтэй хүмүүстэй тус тусдаа хийсэн улирлын хөдөлмөрийн хуваарийн дүн шинжилгээнээс харахад мал маллах, хадлан бэлтгэх, улирлын нүүдэл, галын түлээ бэлтгэх зэрэг олон ажилд эмэгтэйчүүд гар бие оролцдог бололтой байна. Хүүхдийн хөдөлмөр чухал үүрэг гүйцэтгэдэг болох нь ч тодорхой байсан ба тэд ерөнхийдөө зуны амралтаараа мал маллах, гэр цэвэрлэх, дүүгээ харах зэрэг ажлыг хийдэг бөгөөд дунд, ахлах ангийн охид сүү саах, цагаан идээ бэлтгэх зэрэг ажилд тусалдаг хэмээн оролцогчид мэдээлсэн байна. Цэнхэр сумын эмэгтэйчүүд хүүхдийн сургуулийн бэлтгэл ажлыг хичээлийн жил эхлэх бүрт хариуцан гүйцэтгэдэг ба их сургуулийн оюутан хүүхэдтэй айлд улам их бэлтгэл ажил хэрэгтэй байдаг байна. Хичээлийн жилд (9-р сараас 6-р сарын хугацаанд) эмэгтэйчүүд ихэвчлэн хүүхдүүдтэйгээ сумын төвд амьдардаг нь өрхийн эрэгтэй гишүүд өвөлжөөнийхөө бүх ажлыг өөрсдөө хийдэг гэсэн үг юм.

Мөн өрх толгойлсон эмэгтэй уламжлалт хөдөлмөрийн хуваариасаа гадна эрэгтэй хүний хийдэг гэрийн гадаах ажлыг бас хийх хэрэгтэй болдог. Энэ нь нэлээд амаргүй ажил байдаг учир тэд ихэнхдээ өвлийн улиралд хамаатныхаа, ялангуяа эрэгтэй хүнтэй хамаатан садныхаа ойролцоо нүүж очдог. Харин насанд хүрсэн үүтэй өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн хувьд харьцангуй амар байдаг.

Эрэгтэй, эмэгтэй хүмүүс өрх доторх шийдвэрийг ихэнхдээ хамтран гаргадаг ба тэдний аль аль нь баг, сумын хуралд оролцдог ч эмзэг бүлгийн эмэгтэйчүүд тэр бүр зоригтой ярьдаггүй байна. Монгол орны бусад газрын адил малчин өрхийн эхнэр, нөхрийн аль аль нь өрхийн санхүүг хамтдаа хариуцдаг хэдий ч эмэгтэй хүн өдөр тутмын төсвийн менежментийг удирдан явуулдаг байна. Харин мал юмуу тээврийн хэрэгсэл худалдан авах тохиолдолд эрэгтэй хүн шийдвэр гаргадаг талтай.

Түүнчлэн жендэрийн харилцаанд нөлөөлж буй нэг сөрөг асуудал нь архидалт юм. Бидний ЗБУ, ХХЯ-ын үеэр энэ тухай олон дахин яригдаж байсан ба анхны тайлангийн хурал дээр ч дахин яригдаж байв. Эрэгтэйчүүдийн архидалт эмэгтэй хүмүүсийн ажлын ачааллыг нэмэгдүүлээд зогсохгүй эмэгтэйчүүдийн хүчирхийллийг бий болгож байдаг ба архичин хүний эхнэр илүү өртдөг явдал бол Цэнхэр суманд байгаа нэгэн нууцлагдмал асуудал юм. Монгол орны хаа ч ялгаагүй судалгааны үеэр энэ асуудлыг нээлттэй ярилгүй өнгөрөх талтай.

Уул уурхайн компаниуд ба бичил уурхай

Цэнхэр сумын Орхон багт уул уурхай байдаг бөгөөд багийн нийт талбайн 30-40% -г эзэлдэг. Анх 1999 онд том хэмжээний алтны шороон ордны уурхай Орхон багийн Дээд нүүр нэртэй газарт эхэлсэн байдаг. Аймгийн улсын мэргэжлийн хяналтын байцаагчийн мэдээлснээр бидний судалгаа хийж байх үед Дээд нүүрт хүчинтэй лицензтэй таван бизнесийн байгууллага байсан-Алтай голд, БМНС, Голден Хаммер, Монгол газар, МЖХ. Эдгээр компани лицензтэй газрынхаа ус ашигласны төлбөр, хогны төлбөрийг аймагт шууд төлөх үүрэгтэй. Түүнчлэн эдгээр компанийн Монгол газар, МЖХ хоёр нэг эзэнтэй, зөвхөн Алтай голд, БМНС лицензийн гэрээний дагуу зүй зохистой ажиллаж байгаа гэсэн мэдээллийг мэргэжлийн хяналтын газраас бидэнд өгсөн юм. Үүнд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу байгаль хамгаалах, байгаль орчны нөхөн сэргээлт хийх хариуцлага байдаг. Судалгааны явцад аймгийн захиргаанаас мэдээлснээр Монгол газар, МЖХ компанийн эзэн хуулийн цоорхойг ашиглаж компанихаа лицензтэй газраа 15 бизнесийн байгууллагад түрээсэлсэн бөгөөд үүнд Цэнхэр сумын хүмүүсийн жижиг хэмжээний уул уурхайн компаниуд багтаж байгаа юм. Бас лицензтэй Голден хаммер компани бусад жижиг компанид газраа түрээсэлсэн ч үйл ажиллагаа хараахан эхлээгүй байсан ба тэд ч бас байгаль орны нөхөн сэргээлт хийгээгүй байсан.

Аймгийн улсын мэргэжлийн хяналтын газрын мэдээлснээр Монгол газар, МЖХ компаниуд төрөөс гол, нуурын ойролцоо уул уурхай явуулахыг хориглосон “урт нэртэй” хууль гарсны дараа үйл ажиллагаагаа зогсоосон ба олон жил байгаль орчны нөхөн сэргээлт хийгээгүй байна. Ийм учир дээрх хоёр компанийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчны

яамнаас батлалгүй тусгай зөвшөөрлийг нь сунгаагүй байна. Мөн аймгийн захиргааны мэдээлснээр Шинхуа Монгол нэртэй бас нэгэн компани олборлох лицензтэй бөгөөд бүх техник, тоног төхөөрөмжөө Цэнхэр суманд авчирсан байна. Нутгийн иргэд энэ компанийн үйл ажиллагааг эсэргүүцэж тэмцэл хийсэн боловч компани 2018 оны 8-р сарын сүүлээр үйл ажиллагаагаа эхэлсэн байна. 2018 оны 12-р сарын судалгааны тайлангийн хурлуудаас тус компани гүн малтлага хийсэн боловч лицензтэй газарт нь ашигт малтмал олдоогүй бөгөөд ямар ч нөхөн сэргээлт хийгээгүй тухай бид олж мэдсэн юм.

Орхон багаас гадна Цэцэрлэг багийн нутаг Суварга хайрханы урд нуруунд Нарийн хамар нэртэй газар алтны шороон ордны уурхай байдаг ба Монгол газар 13,000 га газрын тусгай зөвшөөрөлтэй ба 2005 онд зөвхөн 68 га-д ашиглалт явуулсан байна. Цэцэрлэг багийн малчид Монгол газар үйл ажиллагаа эхэлсэн даруйд уурхайн талбай дээр суулт хийж, хуульд заасны дагуу лиценз авахдаа нутгийн иргэдтэй зөвлөлдөөгүй зэрэг асуудлын мөрөөр явж зогсоож чадсан байна. Ингээд 2007 онд уурхайн үйл ажиллагаа бүрэн зогсож цаашдаа энэ нутагт уул уурхай явуулахаас сэргийж Монгол улсын засгийн газраас Суварга хайрхан уулыг төрийн тахилгат уул хэмээн зарлиг гаргасан.

Жижиг хэмжээний уул уурхайн компаниудад түрээслэх нь

2010 оны үеээс эхлэн жижиг хэмжээний бизнесийн байгууллагууд Монгол газар, МЖХ, Голден хаммер компаниудаас газар түрээслэн авч жилийн гэрээтэй ажиллаж эхэлсэн байна. Сумын захиргааны мэргэжилтнүүдийн мэдээлснээр 2016 онд нийт 36, 2017 онд нийт 30 жижиг хэмжээний уурхайн компани ажиллаж байсан. Гэхдээ бидний ЗБУ, ХХЯ-ын үеэр хүмүүс Орхон багт 50 иас илүү жижиг компани байгаа гэсэн мэдээлэл өгсөн. Тэдгээр компанийн ихэнх өмнө нь Уянга суманд нинжа байсан (хууль бусаар ажиллаж байсан) хүмүүсийн мэдлийнх бололтой байна. Тэд олон жилийн туршлагатай тул техник хэрэгсэл, олборлолт явуулах арга хэлбэрээ сайжруулж, улмаар хууль ёсны бүртгэлтэй жижиг уурхайн компани болсон байна. Цэнхэр сумын боломжийн амьдралтай хүмүүс энэхүү жижиг хэмжээний гэрээт уул уурхайн бизнес хийж байгаа ба ялангуяа Орхон багийн чинээлэг малчид хэдийгээр Монгол газар компаниас түрээслэн авсан ч олонх нь хууль бусаар жилийн гэрээтэй ажиллаж байна. Учир нь тэд албан ёсны бүртгэлтэй бичил уурхай бус нинжа маягаар ажиллаж, шаардлагатай тоног төхөөрөмжтэй туслан гүйцэтгэгч, өрөмдлөгийн компани хөлслөн ажиллуулдаг бөгөөд ингэснээр ашгийн 70%-ийг тэдэнд өгдөг байна. Зөвхөн үлдэгдэл 30% нутгийн малчинд үлддэг гэсэн үг юм. Гэхдээ эдгээр өрөмдлөгийн компани Цэнхэр сумаас өөр газар бүртгэлтэй жижиг хэмжээний уул уурхай эрхлэгч этгээдүүд юм. Тэд ч мөн Монгол газар компаниас шууд гэрээгээр газар түрээсэлж авсан байдаг ба өөрсдөө урьд нь нинжа байсан хүмүүс юм. Энэ нь гадны хүмүүс нэг бол өөрсдөө газар түрээслэн ажиллаж эсхүл Цэнхэр сумын хувь хүмүүстэй ямар нэгэн байдлаар (хууль бус) ашиг хуваах тохиролцоо хийж уул уурхайн бүх ашгийг хүртэж байгаа мэт харагдаж байна. Мөн том компаниудаас газар түрээслэх гэрээ хийх арга зам тодорхойгүй байдгаас төөрөгдөлт, түрээсийн газрын давхцал зэрэг асуудал үүсгэдэг байна.

Орон нутгийн бичил уурхайчдын эрх зүйн зохицуулалт

Суманд гарч буй дээрх асуудлуудыг зарим талаар зохицуулах үүднээс 2017 оноос нутгийн нинжа нар уул уурхайн үйл ажиллагаагаа албан ёсны болгохын тулд нөхөрлөл байгуулж эхэлсэн. 2018 оны 8-р сарын байдлаар урьд нь хууль бусаар нинжа байсан нийт 100 гаруй гишүүнтэй 10 гаруй уул уурхайн нөхөрлөл байгуулагдсан байсан. Манай ЗБУ-ын оролцогчид ШХА-ийн Тогтвортой бичил уурхайн төслийн дэмжлэгтэйгээр байгуулагдсан Улаанбаатарт төвтэй Монголын бичил уурхайчдын нэгдсэн дээвэр холбоотой зөвлөлдсөний дагуу эдгээр 10 нөхөрлөл эрхээ хамгаалахын тулд төрийн бус байгууллагын статустайгаар байгуулагдсан байна. Учир нь Монгол улсын уул уурхайтай холбоотой хуулинд уул уурхайн нөхөрлөлийн тухай шинэ заалт орсон ч статус нь хараахан баталгаатай болоогүй байгаатай холбоотой юм. Бидний уулзаж ярилцсан нөхөрлөлийн гишүүд нинжа байснаас ялгаагүй, ямар нэгэн өөрчлөлт гараагүй

гэцгээж учир нь уул уурхайн компаниуд нөхөрлөлийн бүртгэлийн гэрчилгээг тоодоггүй бөгөөд харин ТББ –ын бүртгэлийн гэрчилгээтэй бол хамтран ажиллах илүү сонирхолтой байдаг гэсэн юм.

Дээр дурьдсан гэрээт уул уурхайн үйл ажиллагаатай адилаар нутгийн ТББ мөн л гадны бүртгэлтэй туслан гүйцэтгэгч өрөмдлөгийн компанийг хөлслөн авч гэрээ хийх хэрэгтэй болдог ба тухайн компанидаа ашгийн 70%-ийг өгч, нөхөрлөлийн гишүүд үлдэгдэл 30% ийг хуваан авах хэрэгтэй болдог байна. Гэхдээ энэ нөхцөлд байгаль орчны нөхөн сэргээлтийг нөхөрлөл болон гүйцэтгэгч компанийн аль аль нь хийнэ гэсэн үргийг талууд гэрээгээр хүлээдэг бөгөөд сумын захиргаатай гурвалсан гэрээ хийдэг. Олборлосон алтыг гүйцэтгэгч компани, орон нутгийн ТББ хоёр хамтдаа уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигч (Монгол газар) компанид худалдах ёстой байдаг. Гэвч бидний сонссоноор ихэвчлэн гүйцэтгэгч компанийн зүгээс гэрээгээр зөрчин нөхөрлөлийн ахлагчийг хайхралгүй тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниас ашиглалтын үеэр ухсан алтны орцтой шороог (том компанид ийм шорооноос алт гаргах нь эдийн засгийн хувьд ач холбогдолгүй байдаг) шууд авч өөрсдөө алт гарган, худалдаалдаг бөгөөд дараа нь нөхөрлөл энэ шорооноос алт олборлох боломжгүй хоосон үлдээдэг байна.

Уул уурхайн нөлөөлөл

Судалгаа авсан өрхийн хүмүүс уул уурхайн эдийн засгийн үр нөлөөг ярихаасаа илүүтэйгээр орон нутгийн газар, байгалийн нөөцөд үзүүлж буй нөлөөллийг онцгойлон дурьдах нь элбэг байв. Хүмүүс нутгийн байгаль орчинд үзүүлж буй уул уурхайн гол нөлөөллийг “уул уурхай тоос шороо босгож, газар доройтуулдаг”, “уул уурхайгаас болж усны нөөц буурч байна”, “уул уурхай хамтын эзэмшлийн бэлчээрийн газарт дарамт үзүүлж байна”, “уул уурхай газар сайгүй зам гаргаж бэлчээр сүйтгэж, малд аюул учруулдаг” зэргээр нэрлэжээ. Түүнчлэн олон хүн ундны усны чанарт санаа зовниж буйгаа илэрхийлсэн. Сумын хэмжээнд бараг хүн бүр тав болон түүнээс дээш жилээр Цэнхэрийн голоос ундны ус ууж байгаа. Харин голын дээд эх Орхоны уул уурхайгаас болж бохирдолт ихтэй болсон учир хүмүүс усны чанарт итгэхээ больсон байна. Дээд нүүрний зарим иргэд машинаар явж уул уурхайгаас хол очиж голоос ундны усаа авдаг болсон байна. Зарим нь уул уурхайн компаниудын гаргасан гүний худгаас ундны усаа авах болсон. Мөн бидний сонссоноор зарим уул уурхайн компаниуд айл өрхөд том машинаар үнэгүй ус зөөж хүргэдэг байна.

Цэнхэр сумын уул уурхайтай холбоотой байгаль орчны доройтлын гол асуудлуудын нэг нь уул уурхайн компаниуд (хуульд заасны дагуу) нөхөн сэргээлтээ мүү хийдэг явдал юм. Гэхдээ сумын хэмжээнд зөвхөн Орхон багийн нэгээхэн хэсэг газар уул уурхай явагдаж, шууд нөлөөлөлд өртсөн байна. Бидний олж мэдсэнээр Орхон багт юу болж байгааг бусад багийн хүмүүс сайн мэдэхгүй ч Орхоны бэлчээрийн талхагдал уул уурхайгаас болж байна гэж итгэж байсан явдал юм. Мөн түүнчлэн Орхон багийн үндсэн уул уурхайгаас ганцхан давааны цаана амьдарч буй зарим малчид уурхайн байгаль орчинд үзүүлэх бодит нөлөөллийн талаар ойлголт мүү байгааг бид илрүүлсэн. Ялангуяа, олон малтай нутгийн малчид Дээд нүүрнээс хол амьдардаг бөгөөд уурхайн талаар ойлголт муутай, зарим тохиолдолд хамгийн дөт замаар хүрэх газарт байгаа уул уурхайн талаар ер сонирхдоггүй байна.

Уул уурхайн нийгэмд үзүүлэх нөлөө бас байна. Архидалт олширсноор гэмт хэрэг, осол эндэгдэл гарах болсон гэх мэт. Мөн Орхон багт амьдарч буй ахмад малчид уул уурхай явагдах болсноор хүний зан ааш эвдэрч, нутгийн эрэгтэй, эмэгтэй хүмүүс зэрлэг, ширүүн болж буйг бидэнтэй хуваалцсан юм.

Газар олгох үйл явц

Цэнхэр суманд ерөнхийдөө бүх төрлийн газар эдэлбэрийн зохицуулалт сумын төвийн хүмүүс болон хөдөөний багийн малчдын аль альных нь хувьд ялгаагүй уламжлалт хэв маягтай байгаа нь харагдсан. Албан ёсны газар олголт, гэрчилгээжүүлэлт хийх хэрэгтэй газрын хэлбэр бол

сумын төвийн өрхийн хэрэгцээний хашааны газарт өмчлөлийн, өвөлжөө, хаваржааны газарт эзэмших гэрчилгээний эрх авах байдаг. Түүнчлэн Цэнхэр сумын үмүүс тэр бүр холбогдох хууль тогтоомжийг хангалттай мэдэхгүй байсан. Судалгааны ихэнх хариулагч (эмэгтэйчүүдээс эрэгтэйчүүд бага зэргээр олон) газар өмчлүүлэхэд эрэгтэй, эмэгтэй хүмүүст ялгавартай хандах нь хууль бус явдал гэдгийг мэдэж байсан хэдий ч эмэгтэй хариулагчийн 36%, эрэгтэй хариулагчийн 40% Монгол улсын хуулиар эрэгтэй хүний газрын эрх эмэгтэй хүнийхээс илүү гэж үзэж байсан. Мөн хариулагчдийн талаас бага хувь нь газрын эрхтэй байх нь түүний доор байгаа ашигт малтмалын бас эрхтэй гэсэн үг бишээ гэдгийг мэдэж байсан.

Мөн орон нутаг дахь судалгааны үеэр газар өмчлөл гэдгийг хүмүүс ташаа ойлгож байгаа нь мэдрэгдсэн. Сумын төвөөс өөр газарт ихэнх хүмүүс албан ёсны газар өмчлөх юмуу эзэмших эрх аваагүй байсан ч “газар дээрээ” олон үеэрээ амьдарч, ашиглаж ирсэн учир “өөрсдийн өмч” гэж итгэж ирсэн байсан. Харин хөдөөгийн багуудын зарим хүмүүс өвөлжөө, хаваржааныхаа газрын кадастрийн зураглалыг саяхан хийлгэсэн байсан ба үүнийгээ албан ёсны газар эзэмших гэрчилгээ гэж ойлгосон байсан.

Судалгааны ерөнхий мэдлэгийн асуултад хариулагчид сумын байгалийн нөөцийн талаар шийдвэр гаргахад эмэгтэй хүн чухал үүрэгтэй оролцдоггүй гэж үздэг бөгөөд тэдний цөөн хэсэг нь нутгийн газрын менежментийн талаар шийдвэр гаргахдаа тэднийг оролцуулж, зөвлөлддөг гэж үзсэн байна. Гэхдээ Цэнхэр сумын хувьд газар олголт хийгдэх, өргөдөл гаргах үед эмэгтэйчүүд шаардагдах бичиг баримт бэлтгэж, орон нутгийн засаг захиргаатай уулзах ажлыг ихэвчлэн хийдэг байна. Энэ ажлыг хийхэд хөдөөгийн багийн эрэгтэй малчид сумын төвөөс хол амьдардаг учир тэр бүр оролцдоггүй харин тэдний эхнэрүүд хичээлийн жилд сумын төв дээр амьдардаг. Эмэгтэй хүмүүс ажлын ихэнхийг хийдэг ч газар өмчлөлийн гэрчилгээг эрэгтэй хүний нэр дээр гаргадаг. Гэхдээ ихэвчлэн хүмүүс өрхийн хэрэгцээний хашааны газар нэг хүний нэр дээр байсан ч энэ хамтын өмчлөлийнх буюу гэр бүлийн гишүүдийн өмч гэж үздэг байна. Ийнхүү нэг хүний нэр дээр бүртгэл хийх хандлагатай байдаг нь зарим талаар албаны ёсны өргөдлийн маягтууд дээр нэг хүний бүтэн нэр бичихээс илүү зай байдаггүйтэй холбоотой байдаг байж болзошгүй юм.

Өрх толгойлсон, эмзэг бүлгийн хүмүүс бусдын хашааны газар дээр түр зуур амьдрах нь элбэг байдаг ба тэдэнд албан ёсны хашааны газар авахад хүндрэлтэй байдаг. Тэдэнд хашаа барих хөрөнгө мөнгө, гэр бүлийн эрэгтэй гишүүний хүн хүч дутагдалтай байдагтай холбоотой юм.

Өвөлжөө, хаваржаа

Бидний судалгааны үеэр өвөлжөө, хаваржааны газрыг албан ёсоор баталгаажуулан олгож, гэрчилгээжүүлэх үйл явц анхан шатандаа явж байсан. Манай ЗБУ, ХХЯ-ын үеэр олон малчид уламжлалт эрхтэй өвөлжөө, хаваржааныхаа газрын кадастрийн зураглалыг хийлгэж төлбөр төлсөн тухайгаа ярьж байсан юм. Гэхдээ дээр дурьдсанчлан тэдний ихэнх нь үүнийгээ албан ёсны эзэмших гэрчилгээ гэж ташаа ойлгосон байсан. Гэтэл тэдний бидэнд үзүүлсэн гэрчилгээ нь кадастрийн зураглал, төлбөрийн баримт байсан.

Хүнсний ногоо, тэжээлийн тариалангийн газар

Цэнхэр суманд газар тариалан (хүнсний ногоо) бага. Гэхдээ бид Алтан-овоогийн халуун уснаас Тамир ирэх замд тэжээлийн тариалангийн талбай хэд хэдийг олж харсан. Эдгээр нь хашаажуулсан, хэд хэдэн га талбай байсан. Цэнхэр суманд газар тариалан эрхэлж байгаа газрын зохих ёсны баримт бичиггүй хүмүүс байсан ба зарим нь бичиг баримтгүй тариалан эхэлсэн байсан бол зарим хүмүүс бичиг баримт хэрхэн авах мэдээлэлгүй байсан. Оролцооны судалгааны үеэр сумын захиргааны ажилтнуудын мэдээлснээр зөвхөн багийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар дамжуулан хүсэлт гаргасны үндсэн газар тариалангийн газар олгогддог. Хүсэлтийг багийн хурлаар баталвал цааш нь сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал дээр тухайн газрыг тендэрийн журмаар олгох уу, давуу эрхтэй олгох уу зэргийг шийдвэрлэдэг байна. Хэрэв газрыг тендэрээр олговол хамгийн их үнэ хэлсэн өргөдөл гаргагчид олгох бөгөөд

ядуу, эмзэг бүлгийн өрхүүдэд халтай юм. Хэрэв давуу эрхтэйгээр газар олговол газар тариалан эрхэлж байсан туршлагатай нэгэнд олгох бөгөөд ихэвчлэн түрүүлж хүсэлт гаргасан нь авна гэсэн үг. Гадны хүмүүс зөвхөн тендэрт оролцож газар авах боломжтой. Гэсэн хэдий ч багийн хурлаар тендэрийн үр дүнг баталж эцсийн шийдвэр гаргах учир тэдэнд тэр бүр олгодоггүй талтай.

Ой

Цэнхэр сум арвин их ойн дагалдах баялагтай ба орон нутагт арилжааны болон өрхийн хэрэгцээний аль альных нь хувьд мод үнэ цэнэтэй баялаг юм. Жил бүр сумын захиргаа тухайн жилд мод бэлтгэх газрыг тодорхойлдог ба хоёр янзын зөвшөөрөл олгодог: сумын хувь хүмүүсийн түлээний модны зөвшөөрөл, бүртгэлтэй бизнесийн байгууллагуудын гоожингийн зөвшөөрөл. Өрх толгойлсон эмэгтэйд зөвшөөрөл авахад хүндрэл учирдаггүй, гэхдээ түлээний мод авах газар амьдардаг газраас хол заагдвал хүндрэл үүсдэг. Учир нь ачааны машин хөлсөлж түлээний мод татах гэх мэтэд санхүү мөнгөний болоод өөр бусад хүндрэлтэй байх магадлалтай.

Дээр дурьдсанчлан, модноос бусад ойн дагалдах баялгийг түүж, борлуулах нь орон нутагт бэлэн мөнгөний чухал эх үүсвэр бөгөөд ялангуяа сумын ойд ойр амьдардаг ядуу өрхүүдийн хувьд байдал ийм байдаг. Сумын иргэдэд төлбөр төлөхгүйгээр өрхийн хэрэгцээний самар, жимс түүхийг зөвшөөрдөг. Зарим малчид бидэнд зав, хүн хүч байдаггүй гэсэн байхад сумын төвд амьдардаг цөөн малтай хүмүүс дагалдах баялаг түүж хэрэгцээндээ хэрэглэхээс гадна зарж, борлуулдаг гэжээ.

Аялал жуулчлал

Алтан-Овоо багийн нутагт байх халуун ус түшиглэн албан ёсоор аялал жуулчлалын бизнес хийж буй 5 компани биднийг судалгаа хийх үед байсан. Компанийн төлөөлөгчид, нутгийн малчдын яриагаар халуун усны ойролцоох газрын менежмент муу учир байгаль орчны сөрөг нөлөө ихэсч байгаа юм. Жуулчдын урсгалыг зохицуулах олон шинэ зам гарснаар бэлчээр доройтож, бохирын систем хангалтгүй байгаагаас шалтгаалан нутгийн ус ихээр бохирдож байна.

Манай ЗБУ, ХХЯ-ын зарим оролцогчид жуулчлалын компаниуд нутгийн малчидтай зөвлөлддөггүй бөгөөд малчид багийн хуралдаа урихад тэд ирдэггүй хэмээсэн юм. Гэхдээ 2018 оны хавар Алтан-Овоо багт үйл ажиллагаа явуулж байгаа жуулчны компаниуд нутгийн малчидтай хамтран халуун усны ойролцоо дахин шинээр амралтын газар байгуулахын эсрэг амжилттай тэмцэж чадсан байна. Гэхдээ түүнээс хойш компаниудын эзэд, малчдын хоорондын харилцаа дахин суларч зарим нэг шинэ компани орж ирсэн явдал байна.

Газрын маргаан

Манай суурь судалгааны санамсаргүй түүврийн өрхийн 8% нь сүүлийн 12 сарын хугацаанд газар болон эд хөрөнгөтэй холбоотой ямар нэгэн маргаанд оролцсон гэжээ. Бэлчээрийн газартай холбоотой маргаан хамгийн ихээр гардаг хэдий ч манай ЗБУ, ХХЯ-д оролцсон хүмүүс сүүлийн хэдэн жилд дээр дурьдаж байсанчлан уул уурхайн тусгай зөвшөөрөлтэй газрыг түрээсээр ашиглах болсноор түрээсийн газрын давхцлаас үүдэлтэй хүмүүсийн хооронд зөрчил үүсч, маргаан их гарах болсон гэсэн юм. Маргаантай хүмүүс Монгол газар компанид хандсан боловч ямар нэгэн арга хэмжээ авагдаагүй гэдгийг манай судалгааны үеэр хүмүүс хэлж байсан ба тэр хүмүүс энэ нь бүхэлдээ хууль эрх зүйн хувьд тодорхойгүй процесс учир шүүхэд хандаж чаддаггүй гэсэн юм. Гэсэн хэдий ч Аймгийн улсын мэргэжлийн хяналтын газар маргаантай байгаа газрын хил заагийг тогтоох ажил хийж асуудлыг зохицуулахад оролцож эхэлснийг бид олж мэдсэн юм.

Нутгийн малчдын хоорондын бэлчээрийн маргаан цөөн, харин улирлын нүүдлийн үед өөр багийн малчдын хооронд зөрчил үүсдэг ч хоорондоо албан бусаар тохиролцож шийддэг бололтой байна. Харин өөр сумын малчид Цэнхэр суманд ирж малаа бэлчээрлүүлэхтэй

холбоотой томоохон хэмжээний бэлчээрийн маргаан гардаг байна. Бусад сумдад гарч байгаа малын тооны өсөлт, уул уурхайн бэлчээрийн газарт үзүүлж буй сөрөг нөлөө зэрэг үзэгдэл энд мөн адил байна. Мөн гадны малчид отороор хол нүүж Цэнхэр суманд орж ирэхэд газрын маргаан үүсдэг.

Манай ЗБУ, ХХЯ-ын хэд хэдэн оролцогч сүүлийн хэдэн жилд бэлчээрийн маргаан их гарах болсон тухай сэтгэгдлээ хуваалцсан. Ихэнх тохиолдолд нүүр нүүрээ тулан ярилцаж харилцан ойлголцолд хүрдэг ч зарим тохиолдолд зодоон цохион, доромжлох явдал гардаг тухай зарим хүн мэдээлсэн байна. Асуудал хүндэрсэн үед хүмүүс багийн засаг даргад мэдээлж маргааныг шийдвэрлүүлэхээр ханддаг ч хууль эрх зүйн хүрээнд бэлчээрийн газрын маргааныг шийдвэрлэх тодорхой механизм байхгүй гэдгийг судалгаанд оролцогчид мэдээлсэн юм. Мөн эрэгтэй, эмэгтэй хариулагчдийн бараг хагас нь газар болон байгалийн нөөцтэй холбоотой маргааныг шийдвэрлүүлэхэд амаргүй гэж хэлсэн байна.

Мөн бидний ойлгосноор өвөлжөө, хаваржааныхаа кадастрийн зураглал хийлгэсэн боломжийн амьдралтай айл өрхүүд тэр бичиг баримтаа ашиглан Монгол улсын хуульд заагдсаны дагуу бууц хорооныхоо эргэн тойрны 500 м радиусын газрыг зөвхөн өөрсдөө ашиглах бэлчээр болгон баталгаажуулахад ашиглаж эхэлсэн байна. Гэхдээ нутгийн малчид өөрсдийгөө үүнээс ч цааших газрын уламжлалт эрхтэй гэж үздэг. Бидний судалгааны үеэр олж мэдсэн маргааны олонх нь нэг талаас энэхүү нутгийн малчдын бэлчээр ашиглах эрх албажаагүй байдал, нөгөө талаас малчдын өөрсдийн ойлгож байгаа уламжлалт практикт үндэслэсэн зүй ёсны эрх хоёрын хоорондын зөрүүтэй байдлаас үүдэлтэй байна.

Бидний оролцооны судалгаагаар мэдэгдсэн бас нэгэн төрлийн маргаан нь малын хулгай байв. Сүүлийн жилүүдэд малын хулгай ихсэх болсон тухай олон хүмүүс хэлж байв. Хөдөөгийн өрх айлууд алс хол, бие биенээсээ зайтай, харьцангуй жижиг хот айлын хэмжээнд амьдардаг учир малын хулгайчдыг мөшгин барихад хүндрэлтэй байдаг байна.

Бэлчээрийн менежмент

Бидний оролцооны судалгааны үеэр нутгийн малчид 5 жилийн өмнө бол бэлчээрийн газрын тухай санаа зовних зүйлгүй байсан, харин одоо малын тоо өсч, уул уурхайн үйл ажиллагаа явагдах болсонтой холбогдоод сумын бэлчээрт нүүрлэх аюул ихэсч байна, албан зохицуулалт хэрэгтэй гэсэн юм.

ЗБУ, ХХЯ-д оролцсон ахмадууд сумын бэлчээр бороо хүр орох нь багассан, орсон ч хавар их орой ордогтой холбогдоод сумын бэлчээр муудаж байгаа тухай ярьсан юм. Нутгийн ахмад хүмүүс жил ирэх тусам бүх гол, горхиний усны түвшин буурах хандлагатай бөгөөд энэ нь уламжлалт бэлчээрийн мал аж ахуйд нөлөө үзүүлж байна, гол болон бусад усны нөөц рүү дөхөж буух малчин өрхийн тоо нэмэгдэж байгаа учир тэр орчмын бэлчээрийн талхагдал улам бүр ихэсч байгаа тухай ярьсан юм. Энэ нь цаагуураа уур амьсгалын өөрчлөлтийн чиг хандлагатай холбоотой байж болох юм.

Цэнхэр сум нийтийн эзэмшлийн бэлчээртэй. Суурь судалгааны бүх өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн 18%, эрэгтэй тэргүүнтэй өрхийн 11% мал бэлчээдэггүй гэсэн юм.

Мал маллах хөдөлмөрийн хуваарь хот айлд түшиглэсэн, эдийн засаг, нийгмийн харилцааны харилцан хамааралтай комплекс нөхцөлд явагддаг байна. Олон хүмүүс малаа маллахдаа түслуулах төлбөртэй болон төлбөргүй хариулах хүн, хамаатан садандаа найддаг. Ялангуяа эмзэг бүлгийн юмуу өрх толгойлсон эмэгтэйтэй өрх малчин байхын тулд бусдын дэмжлэгэд найддаг байна. Ямарч хүйсийн ахмад настай өрхийн тэргүүнтэй айл эсхүл өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн аль аль нь бусад айлд малаа өгч (ялангуяа өвлийн улиралд) харуулах хандлагатай байдаг. Ахмад настай бэлэвсэн хүмүүс олон малтай байхаас халгадаг учир хамаатандаа, ялангуяа насанд хүрсэн гэрлэсэн хүүхдүүддээ малаа өгч маллуулдаг байна. Ингэснээр сумын төвд удаан хугацаагаар амьдарч эрүүл мэндийн үйлчилгээнд ойртож, сургуульд сурч байгаа ач

зээ нараа асран хамгаалах боломжтой болдог. Ийм төрлийн харилцан хамааралтай гэр бүлд суурилсан зохицуулалт нь Цэнхэр сумын эмзэг бүлгийн өрхийг мал маллан бие даан амьдарч, мөнгөн орлого (мөнгөн бүс) олоход тус дөхөм болдог байдалтай харагдаж байна.

Хадлангийн талбай

Бидний ажигласнаар уулын амны доод талаар амьдардаг малчдад өвлийн улиралд малаа тэжээх хадлан хэрэгтэй болдог бол амны дээд талаар амьдардаг малчид малаа авч оторт гарах хандлагатай байдаг. Хадлан хэрэгтэй байдаг нутгийн малчид өөрсдийн уламжлалт эрхтэй газраасаа хадлан хийх нь түгээмэл үзэгдэл. Гэвч сүүлийн үед олон малтай малчид хадлангийн том талбай хайдаг болсонтой холбоотой асуудал үүсч байгаа бөгөөд тэд цөөн малтай малчин өрхийн хадлангийн газраас бага багаар авах болсон байна. Энэ нь үнэндээ суманд малын тоо өсч, бэлчээр талхагдаж байгаа гэж хүмүүс үзэж байгаатай холбоотой. Нутгийн малчид, захиргааны ажилтнуудын аль аль нь төрөөс хадлангийн газрын талаар ямар нэгэн зохицуулалт хийдэггүй учир хүмүүс уламжлалт аргаар зохицуулдаг гэсэн байна. Ямар нэгэн албан зохицуулалт хийж, хил зааг тогтоохгүй бол чинээлэг, ядуу малчдын ялгаа их гарах тусам яваандаа хадлангийн газар дээр зөрчил гарах магадлалтай байгааг хүмүүс хэлж, ярьж байсан.

Улирлын болон отрын нүүдэл

Цэнхэр сумын бэлчээрийн менежментийн гол үндэс малын улирлын болон отрын нүүдэл юм. Өөр өөр багийн малчдын бидэнд өгсөн мэдээллийг харьцуулан харахад сүүлийн 10 жилийн туршид нүүдэл ихэнхдээ хаваржаа, өвөлжөөний хооронд, хамгийн холдоо 100 км, хамгийн ойрдоо 5-10 км нүүдэллэдэг байна. Уулархаг газар амьдардаг оторт гарсан малчид жилдээ 6 удаа хол зайд нүүх явдал энүүхэнд байдаг байна.

Улирлын болон отрын нүүдэл хийх ажил өрх толгойлсон эмэгтэйтэй малчин өрхийн хувьд гол хүндрэлтэй асуудал болдог байна. Гэр бүлийн эрэгтэй гишүүнгүй бол ялангуяа отрын нүүдэл хийх маш хэцүү, учир нь өвөл цагт гэр бүлийн гишүүдээ өвөлжөөндөө үлдээгээд оторт зөвхөн эрэгтэй хүмүүс явдаг. Ийм учир өрх толгойлсон эмэгтэйтэй өрх тэдэнд улирлын нүүдэл хийхэд туслах, оторт явахдаа малыг нь хамт аваад явах эрэгтэй хүнтэй хамаатнаа бараадан амьдардаг байна. Манай ЗБУ, ХХЯ-ын оролцогчид 15 юмүү 20 жилийн өмнө зөвхөн хэцүү өвөл хүндэрсэн, ногоо гарахгүй жилд л оторт явдаг байсан бол өнөө үед бэлчээр муудаж байгаатай холбоотой илүү олон удаа оторт гарах болсон гэж ярьсан юм.

Дээр дурьдсанчлан зэргэлдээх аймаг, сумдын малчид Цэнхэр суманд отроор орж ирдэг болсон нь суманд газрын маргаан гарах болсон шалтгаан юм. Гэхдээ энэ байдал одоогийн байдлаар асуудал гэж үзэхээргүй байгаа бөгөөд цаашлаад гадны малчид орж ирэх нь улам ихэсвэл асуудал үүсэхээр байна. Судалгаа хийж байх үед орон нутгийн засаг захиргаанаас отор нүүдлийн ямар нэгэн зохицуулалт, дүрэм журам хийгдээгүй байсан. Гэхдээ Швейцарийн хөгжлийн агентлагийн Ногоон алт төсөл, Орхон багт хэрэгжих Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн Тогтвортой бэлчээрийн менежмент төслийн дэмжлэгтэйгээр тус тус бэлчээрийн менежментийг сайжруулах ажил хийгдэх төлөвтэй байна.

Өрх толгойлсон эмэгтэйтэй өрхөд тулгардаг бэрхшээл

Цэнхэр суманд өрх толгойлсон малчин өрхөд олон бэрхшээл тулгардаг тухай энэ хэсэгт өгүүлнэ. Уламжлалт мал ахуй эрхлэх хэв маяг тэдэнд хүндээр тусдаг, ялангуяа тэд том болсон эрэгтэй хүүхэдгүй бол өдөр тутам аж ахуй эрхлэх – галын түлээ бэлтгэх, мал муулах зэрэг ажилд бусдаас тусламж гүйх хэрэг гардаг. Орон нутгийн хэв заншлийн дагуу эдгээр ажлыг эрэгтэй хүн хийх ёстой байдаг байна. Гэхдээ малгүй сумын төв гэх мэт суурин газар амьдарч буй өрх толгойлсон эмэгтэйтэй өрхөд ч олон бэрхшээл тохиолддог. Бидний олж мэдсэнээр тэдэнд хашааны газар олж авахад асар хүндрэлтэй байх тохиолдол байдаг. Учир нь тэд авсан газраа тойруулан хоёр жилийн дотор хашаа хатгаагүй бол улсаас тус газрыг буцааж авах өндөр магадлалтай байдаг байна. Бидний ЗБУ, ХХЯ-ын үеэр цөөн хэдэн эрэгтэй эмзэг бүлгийн эмэгтэй

малчдад тусалж анхаардаг гэсэн. Гэсэн хэдий ч энэ нь бидэнтэй ярилцсан ихэнх өрх толгойлсон эмэгтэйчүүд тэдний бодол санааг хайхарч авч үзнэ гэж боддоггүй учир баг, сумын хуралд очдоггүй, мөн хуулийн дагуу хүүхдүүдээ сургуульд сургах, мал аж ахуйгаа эрхлэх гээд аль альныг нь хослуулахын тулд их хичээж зүтгэдэг гэсэн олон баримт, нотолгоотой дүйцэхгүй байна.

Дүгнэлт

Социализм нуран унаж ардчилсан нийгэмд шилжсэнээс хойшхи сүүлийн 25 гаруй жилийн хугацаанд нийгэм, эдийн засгийн томоохон өөрчлөлт гарсан Монгол орны бусад зарим газартай адилгүй Цэнхэр сумын хүмүүс зарим талаараа их бага өөрчлөгдсөн гэж хэлж болохоор байна. Залуу үе эдийн засгийн зохицуулалт болон нийгмийн харилцаа хоорондоо хамааралтай, өнө эртнээс уламжлагдан ирсэн жендэрийн норм бүрэлдсэн хот айлын системд суурилсан бэлчээрийн менежмент, газрын хэвшмэл эрхтэй уламжлалт мал аж ахуйгаа эрхэлсэн хэвээр байна. Түүний хажуугаар залуу малчдын дунд уламжлалт мал аж ахуй аажмаар өөрчлөгдөж байгаа бололтой. Жишээ нь, тэд морь малаа сургахаа больсон гэж ахмадууддаа зэмлүүлдэг ч мотоцикль унахыг илүүд үздэг. Түүнчлэн Орхон багийн уул уурхай явагдаж байгаа хэсэгт байгаль орчин, бэлчээрийн доройтолд орсон ч бусад багийн нутагт бэлчээрийн доройтолтой холбоотой асуудал бага, магадгүй уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой хур бороо багатай зун цагт л асуудал үүсдэг байна.

Сумын төвийн Тамир багийн өрхүүд газар өмчлөлийн эрхээ авах боломжтой бөгөөд сумын захиргаанаас хөдөөний таван багийн өвөлжөө, хаваржааны газрын эзэмшлийн гэрчилгээ олгох ажлыг эхлүүлсэн. Биднийг судалгаа хийж байх үед Монгол орны бусад сумтай харьцуулахад Цэнхэр суманд газрын маргаан харьцангуй бага байдаг бололтой байсан ба зэргэлдээх сумын малчид өвлийн бэлчээр хайж орж ирэхэд илүү томоохон маргаан үүсдэг байна. Нутгийн малчдын хооронд хадлангийн газрын талаар зарим зөрчил байдаг нь тодорхой байсан ч ихэнх маргааныг нутгийн хүмүүс хоорондоо хэлэлцэн өөрсдөө шийддэг байна. Нөгөө талаар, байгаль орчны доройтол энэ чигээрээ үргэлжлэн, малын тоо өссөн хэвээр, албан ёсны дүрэм, журам, зохицуулалт хийхгүй байвал бэлчээрийн газрын маргаан ирээдүйд хурцдаг болзошгүй гэдэгтэй манай ЗБУ, ХХЯ-ын оролцогчид санал нэг байв. Мөн малын хулгай нийтлэг болж байгаа нь нутгийн олон хүний сэтгэлийг зовоож байна.

Уул уурхайн үйл ажиллагаанаас сумын арвин их байгалийн баялагт шууд аюул үүсч байна. Мөн халуун ус, рашааны ойролцоох аялал жуулчлалын үйл ажиллагаа ус бохирдуулдаг явдал ихэсч байна. Орхон багийн Дээд нүүрт байрлах уул уурхайн гол цэгт эмх замбараагүй байдал үүссэн бөгөөд албан ёсоор эрх авсан жижиг компаниуд, нинжа нартай шууд хамт ажиллаж байгаа бололтой. Уул уурхайн хэсгүүд зохион байгуулалтгүй, зохицуулалтгүй байсан бөгөөд албан үсны уул уурхай, нөхөрлөл (албан ёсны), нөхөрлөлийн бүртгүүлсэн ТББ-ын кемпуудыг нинжа (хууль бус) нарынхаас ялгахад хэцүү байсан. Уул уурхайн компаниуд байгаль орчны нөхөн сэргээлт хийж байгаа гэж хэлсэн ч бид нэг л компанийг олж харсан нь БМНС юм. Энэ байгууллагын газар зохион байгуулалттай, нүдэнд харагдахуйц газрын нөхөн сэргээлт хийсэн байсан.

Цэнхэр сумын ус, бэлчээрийн нөөцөд уул уурхай хамгийн том нөлөө үзүүлж байна. Орхон багийн хүмүүс голоос ундны усаа авах боломжгүй, уул уурхайн компаниудын гаргасан гүний худгаас авдаг болсон. Гэтэл голын доод хэсгийн бохирдол урьд нь Цэнхэр голоос ундны ус авдаг байсан сумын бүх хүнд нөлөө үзүүлж байна. Анх Дээд нүүрт уул уурхай эхэлж байхад олон малтай малчид сайн бэлчээр хайж уулнаас доош дээд хөндий рүүгаа буусан бол цөөн малтай малчид уурхайн хажууд мал маллангаа уурхай эрхэлж орлогоо нэмэгдүүлэх зорилгоор тэндээ үлдсэн байна. 1990 ээд оноос эхэлсэн уул уурхайн талаар нутгийн малчид сайн мэдээлэлгүй байсан бөгөөд хэлснийх нь дагуу ямар нэгэн нөхөн төлбөр авалгүй нүүж явцгаасан. Бидний судалгаа хийж байх үед ч олон хүн, ойролцоох хөндийн хүмүүс мөн адил

мэдээллээр дутмаг, Дээд нүүрт явагдаж байгаа уул уурхайн талаар сонирхдоггүй бололтой байсан. Нөгөө талаар, Орхон багийн иргэд уул уурхайгаас тодорхой ашиг хүртдэг нь ойлгомжтой байсан. Ихэнх нь нинжа эсхүл нөхөрлөл байгуулж албан ёсоор ажиллаж, Орхоны боломжийн амьдралтай зарим хүмүүс уул уурхайн газрыг түрээслүүлж, өрөмдлөгийн компанитай гэрээ хийж арай томхон хэмжээгээр ажиллах боломжтой болсон байна. Зарим нутгийн малчид уул уурхайн компанид мах, сүү борлуулж ашиг орлого олдог байна.

Аажмаар, зарим талаар уул уурхайгаас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн өөрчлөлтүүд гарч байна. Сумын хэмжээнд архидалт маш том асуудал, ялангуяа Дээд нүүрт жил ирэх тусам нэмэгдэж байна. Машин, мотоциклийн аваар осол нийтлэг байдаг ба энэ нь бэлэвсэн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тоо өсч байгаатай холбогдоно. Мөн манай ЗБУ, ХХЯ-ын оролцогчид нутгийн хүмүүсийн зан чанар хурц ширүүн болсон шалтгаан нь нийгэм, эдийн засгийн харилцан хамааралтай уламжлал болон хот айлын ах дүү, нутгийн хүмүүсийн харилцаанд суурилсан бэлчээрийн мал аж ахуйгаасаа холдсоных гэж байсан юм. Эдгээр өөрчлөлт нь гэр бүлийн болон жендэрт суурилсан хүчирхийлэл гарах болсонтой холбогдох учиртай. Энэ тухай шүүд ярилцаагүй ч ийм байдал суманд оршин байна.

Цэнхэр суманд байгаа бас нэг нийгмийн томоохон асуудал бол хүүхдийн сургуулийг зургаан наснаас эхлүүлэх төрийн бодлоготой холбогдож гарсан залуу малчин өрхөд тулгарч буй асуудал юм. Үүнээс болж гэрлэсэн олон залуу эмэгтэй сумын төвд хүүхдүүдтэйгээ жил бүр 8-9 сарын хугацаанд амьдарч нөхөр нь малаа хариулж гэртээ үлддэг болсон байна. Энэ байдал нь өрх айл жилийн ихэнх сард тусдаа амьдрахаас өөр аргагүйд хүрч дарамт болж байгаа бөгөөд богино, дунд, урт хугацааны үр нөлөөлөл нь хараахан илэрч гараагүй байна. Наад зах нь өсч торниж буй үр хүүхдүүд сумын төвд сургуульд сурснаар өөрсдийн төрсөн ахуйгаасаа холдож байна гэж зарим нэг ахмадууд хэлж байсан юм. Дараагийн нийгмийн нэг гол асуудал бол олон эмэгтэй Улаанбаатар хот руу сургуульд яваад буцаж ирдэггүй учир дунд сургуулийн боловсролгүй залуу малчин эрэгтэйд эхнэр олдохгүй байх явдал юм. Сумандаа үлдсэн залуу эрэгтэй хүмүүс настай эцэг эхээ асардаг. Ялангуяа өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн амьдралд түстэй байдаг. Энэ нийгмийн өөрчлөлтийн урт хугацааны үр нөлөөг урьдчилан харахад хэцүү. Учир нь уул уурхай, аялал жуулчлалын хөгжилтэй уялдсан нийгэм, байгаль орчны бусад бүх асуудлуудтай холилдон дарагдаж болно. Цаашдаа эдгээр асуудлын үр нөлөөлөл илүү тодорхой гарч ирж магадгүй юм.

